| 210807      | Газрын төлбөр                                                              | 00.00                        | 25,395,542.00                |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                     | <b>19,177,015.00</b>         | <b>5,373,400.00</b>          |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                          | 4,101,000.00                 | 5,373,400.00                 |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                                    | <b>250,000.00</b>            | <b>56,975,000.00</b>         |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                              | <b>250,000.00</b>            | <b>56,975,000.00</b>         |
| 213204      | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал                             | 250,000.00                   | 56,975,000.00                |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>                    | <b><u>131,900,384.24</u></b> | <b><u>837,649,628.19</u></b> |
| <b>5</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>                           | <b>130,659,600.00</b>        | <b>99,045,195.00</b>         |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                                                    | <b>130,659,600.00</b>        | <b>99,045,195.00</b>         |
| <b>2200</b> | <b>Дотоод эх үүсвэрээр</b>                                                 | <b>130,659,600.00</b>        | <b>99,045,195.00</b>         |
| 225106      | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал                             | 130,659,600.00               | 99,045,195.00                |
| <b>6</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b> | <b><u>130,659,600.00</u></b> | <b><u>-99,045,195.00</u></b> |
| <b>8</b>    | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>                           | <b>1,240,784.24</b>          | <b>738,604,433.19</b>        |
| <b>9</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>                    | <b>571,577.58</b>            | <b>1,812,361.82</b>          |
| <b>10</b>   | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>                   | <b>1,812,361.82</b>          | <b>740,416,795.01</b>        |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт                                         | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц              | Хуримтлагдсан дүн                  | Бусад        | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|--------------------------------------------------|---------------------------------|------------------------------------|------------------------------------|--------------|-----------------------------------------|
| <b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | 00.00                           | 1,058,452,935.6 <sub>4</sub>       | 3,764,659,883.5 <sub>9</sub>       | 00.00        | 4,823,112,819.2 <sub>3</sub>            |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       | 00.00                           | 00.00                              | 00.00                              | 00.00        | 00.00                                   |
| <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>                | <b>00.00</b>                    | <b>1,058,452,935.6<sub>4</sub></b> | <b>3,764,659,883.5<sub>9</sub></b> | <b>00.00</b> | <b>4,823,112,819.2<sub>3</sub></b>      |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт          | 00.00                           | 00.00                              | 00.00                              | 00.00        | 00.00                                   |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт        | 00.00                           | 00.00                              | 00.00                              | 00.00        | 00.00                                   |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз    | 00.00                           | 00.00                              | 00.00                              | 00.00        | 00.00                                   |
| Тайлант үеийн үр дүн                             | 00.00                           | 00.00                              | 298,440,262.04                     | 00.00        | 298,440,262.04                          |
| <b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>     | <b>00.00</b>                    | <b>1,058,452,935.6<sub>4</sub></b> | <b>4,063,100,145.6<sub>3</sub></b> | <b>00.00</b> | <b>5,121,553,081.2<sub>7</sub></b>      |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт       | 00.00                           | 00.00                              | 00.00                              | 00.00        | 00.00                                   |
| <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>                | <b>00.00</b>                    | <b>1,058,452,935.6<sub>4</sub></b> | <b>4,063,100,145.6<sub>3</sub></b> | <b>00.00</b> | <b>5,121,553,081.2<sub>7</sub></b>      |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00                           | 00.00                              | 00.00                              | 00.00        | 00.00                                   |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт                  | 00.00                           | 00.00                              | 00.00                              | 00.00        | 00.00                                   |

|                                               |              |                         |                         |              |                         |
|-----------------------------------------------|--------------|-------------------------|-------------------------|--------------|-------------------------|
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00        | 00.00                   | 00.00                   | 00.00        | 00.00                   |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү            | 00.00        | 00.00                   | 00.00                   | 00.00        | 00.00                   |
| Тайлант үеийн үр дүн                          | 00.00        | 00.00                   | 1,239,404,236.08        | 00.00        | 1,239,404,236.08        |
| <b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>  | <b>00.00</b> | <b>1,058,452,935.64</b> | <b>5,302,504,381.71</b> | <b>00.00</b> | <b>6,360,957,317.35</b> |

### 3.Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Давтан сургалт, сургалт сэргээн заслын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Давтан сургалт, сургалт сэргээн заслын төв 113 дугаар ангийн захирагч Ц.Уранчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын гэрээгээр Хаан консалтинг Аудит ХХК-ийн аудитор А.Даваасүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Давтан сургалт, сургалт сэргээн заслын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 16/23 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Давтан сургалт, сургалт сэргээн заслын төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Давтан сургалт, сэргээн заслын төв нь Онцгой байдлын ерөнхий газар, түүний харьяа газар, хэлтэс, анги, салбаруудын ажилтан, албан хаагч, тэдний гэр бүлд урьдчилан сэргийлэх үзлэг, ажиллагааны дараах нөхөн сэргээх болон сэтгэл зүйн эмчилгээндүүдэд хамруулах;
- Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг ахиулах богино хугацааны давтан сургалтыг 100-120 хүний багтаамжтай, ухаалаг шийдэлтэй индэр, проектор, утастай, утасгүй микрофон, орчуулгын төхөөрөмж бүхий хүчин чадалтай сургалтын танхимаар зохион байгуулан ажиллах;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын хууль өөрчлөгдсөнтэй холбоотой сувилалын тарифыг Онцгой Байдлын Ерөнхий газрын даргын тушаал 2020 оны 02 дугаарын сарын 10-ны А/44 дугаар тушаалын дагуу өөрчлөгдсөн байна.

### 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Давтан сургалт, сургалт сэргээн заслын төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Сангийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж хийгээгүй байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн орлогоос 2,416,479.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 24,164.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Давтан сургалт, сургалт сэргээн заслын төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,763,209.0 мянган төгрөгөөр буюу 33.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| /мянган төгрөг/                                   |                    |                    |                    |
|---------------------------------------------------|--------------------|--------------------|--------------------|
| Үзүүлэлт                                          | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өөрчлөлт           |
| Б                                                 | 1                  | 2                  | 3=2-1              |
| Мөнгөн хөрөнгө                                    | 1,812.3            | 740,416.8          | 738,604.4          |
| Авлага                                            | 7,350.9            | 5,607.0            | (1,743.9)          |
| Урьдчилгаа                                        | -                  | 1,337.6            | 1,337.6            |
| Бараа материал                                    | 439,463.4          | 798,820.9          | 359,357.4          |
| Үндсэн хөрөнгө                                    | 4,772,662.0        | 5,438,315.4        | 665,653.4          |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>5,221,288.8</b> | <b>6,984,497.8</b> | <b>1,763,209.0</b> |
| Өр төлбөр                                         | 99,735.7           | 623,540.5          | 523,804.7          |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 5,121,553.0        | 6,360,957.3        | 1,239,404.2        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>5,221,288.8</b> | <b>6,984,497.8</b> | <b>1,763,209.0</b> |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 740,416.8 мянган төгрөгөөр өссөн нь шинэ үйлдвэр байгуулах, дээд шатны байгууллагаас үзүүлсэн санхүүгийн дэмжлэгээс шалтгаалжээ. Энэ нь Монгол улсын засгийн газрын тогтоолоор Хувцас хэрэглэл туршилт үйлдвэрлэлийн төвийг шинээр үүсгэн байгуулж, ОБЕГ-ын даргын 2020 оны 01 сарын 10-ны өдрийн А/09 дугаар тушаалаар тус ангийн бүтцэд өөрчлөлт оруулж, үйл ажиллагааг нь нэгтгэснээр харилцах дансанд хувцасны үнэ болох 754,500.0 мянган төгрөгийг төвлөрүүлэн оны эцэст 507,700.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Мөн ОБЕГ-аас тус ангид байрны ариутгал халдваргүйтгэл, засвар үйлчилгээ хийх 250,000.0 мянган төгрөгийн санхүүжилт өгснөөс 230,000.0 мянган төгрөгийн харилцахын үлдэгдэлтэй байна.

Авлага дансны үлдэгдэл 5,607.0 мянган төгрөг болж 1,743.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдэл авлага төлөгдснөөс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2019 онд үүссэн 786.0 мянган төгрөгийн сувилуулагч болон ажилтнаас авах авлага байна.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 1,337.7 мянган төгрөг болж 1,337.7 мянган төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-т түрээсийн илүү төлөлт хийснээс шалтгаалжээ. Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэлд ТӨБЗГ-ын түрээсийн зардалд 1,200.0 мянган төгрөгийн илүү төлөлт, Петростар ХХК-ийн шатахууны картанд шилжүүлсэн 137.7 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэл байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 798,820.9 төгрөг болж 359,357.4 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авалт болон хандив тусламжаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд өөрийн хөрөнгөөр 791,572.0 мянган төгрөг, хандив тусламжаар 404,573.0 мянга, дээд шатны байгууллагаас 422,658.3 мянган төгрөгийн бараа материал хүлээн авч нийт 1,618,803.3 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, үйл ажиллагаандаа 902,038.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 331,516.9 мянган төгрөгийн албаны хувцасыг ОБЕГ-т шилжүүлэн өгч, 25,890.1 мянган төгрөгийн бараа материал акталж, нийт 1,259,445.8 мянган төгрөгийн бараа материал хасагдсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,438,315.4 мянган төгрөг болж 665,653.4 мянган төгрөгөөр өссөн нь хандив тусламж болон худалдан авалтаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгө данс нь дээд шатны байгууллагаас 677,409.3 мянган төгрөг, хандив тусламжаар 72,732.8 мянга, ТӨБЗГ-ын 59 дугаар тогтоолоор дахин үнэлсэн 89,398.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, өөрийн хөрөнгөөр 99,045.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

Үндсэн хөрөнгө нь ТӨБЗГ-ын 2020 оны 03 дугаар сарын 59 дугаар тогтоолоор 474,475.9 мянган төгрөгийн хөрөнгө дахин үнэлэгдэж, 2020 оны 05 дугаар А-1/946 дугаар албан тоотоор үнэ төлбөргүй шилжүүлсэн 30,000.0 мянган төгрөг, 2020 оны 11 дүгээр сарын 594 дугаар тогтоолоор 57,633.7 мянган төгрөгийн хөрөнгө данснаас хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 623,540.5 мянган төгрөг болж 523,804.7 мянган төгрөгөөр өссөн нь ОБЕГ-ын даргын 2020 оны 01 сарын А/09 дугаар тушаалаар тус ангийн бүтцэд өөрчлөлт оруулан Хувцас хэрэглэл туршилт үйлдвэрлэлийн төвтэй нэгтгэж, хувцасны үнийг урьдчилж шилжүүлсэн орлогоос шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд байгууллагад төлөх өглөг 7,883.0 мянган төгрөг, хувь хүмүүст төлөх өглөг 40.8 мянган төгрөг багтсан байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэлд ОБЕГ-с Хувцас хэрэглэл туршилт үйлдвэрлэлийн төвд хувцасны үнэнд шилжүүлснээс 612,117.0 мянган төгрөг, ТӨБЗГ, Мобиком ХХК, Скайтел ХХК, Юнител ХХК-иудтай байгуулсан гуравласан гэрээний барьцаа төлбөр 500.0 мянган төгрөг, удирдах ажилтнуудын хоолны төлбөрт шилжүүлсэн хоолны 3,000.0 мянган төгрөг багтсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,360,957.3 мянган төгрөг болж, 1,239,404.2 мянган төгрөгөөр өссөн нь хандив тусламжаар хүлээн авсан бараа материал, хөрөнгө нэмэгдснээс шалтгаалжээ.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,950,538.3 мянган төгрөгөөр буюу 53.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан 2,051,375.5 мянган төгрөгийн орлого байгаагийн 905,186.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 430,068.6 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 716,120.0 мянган төгрөгийн дээд шатны байгууллагаас олгосон мөнгөн хөрөнгийн орлого байна.

Тайлант онд үүссэн онцгой нөхцөл байдлаас шалтгаалан ОБЕГ-аас 383,387.5 мянган төгрөгийн алба хаагчдын тусгай хувцас хэрэгсэл, 16,265.8 мянган төгрөгийн цахилгааны төлбөр, 699,854.2 мянган төгрөгийн үйл ажиллагааны болон засварын ажлын санхүүжилт, томилолт урамшуулал, 567,659.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлсэн байна. Нийслэлийн ОБГ-аас 85,000.0 мянган төгрөгийн хөл бөмбөгийн талбайн сайжруулалт, 3,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хандивласан. ОБЕГ-ын Улсын нөөц объект 3 байгууллагаас 87,395.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 21,750.0 мянган төгрөгийн бараа материалыг хүлээн авсан байна. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийснээс 89,396.9 мянган төгрөг, хандив тусламжаар 203,328.5 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 1,076,074.3 мянган төгрөгөөр буюу 110.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 142,203.0 мянган төгрөгийн гэрэл цахилгаан, 58,882.2 мянган төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлс, 77,245.7 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл, 213,195.7 мянган төгрөгийн хоол хүнс, 14,877.9 мянган төгрөгийн нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлууд байна.

Давтан сургалт, сургалт сэргээн заслын төв нь тайлант онд бий болсон цар тахалтай холбоотойгоор Улсын онцгой комиссын 4 дүгээр хуралдааны тэмдэглэлээр онцгой нөхцөл байдлын бүс болж, тусгай үүргийн нислэгээр ирсэн иргэдийн тусгаарлалтын байр болсон шийдвэртэй холбоотойгоор дээрх материаллаг хэмжээний зардлууд гарсан байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг өөрийн орлогоос 556,297.0 мянган төгрөгөөр, улсын төсвөөс 1,122,568.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,678,865.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, Онцгой Байдлын Ерөнхий газарт хүргүүлсэн байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,122,568.8 мянган төгрөгийг төлөвлөсөн ч улсын төсвөөс санхүүжилт олгогдоогүй байна.

Гүйцэтгэлээр үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 1,099,202.4 мянган төгрөг, Онцгой Байдлын Ерөнхий газрын санхүүжилтээр томилолт урамшуулалд 717,984.2 мянган төгрөг, Хувцас хэрэглэл туршилт үйлдвэрлэлийн төвийн хувцасны орлого 754,500.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,734,036.9 мянган төгрөг,

хөрөнгө худалдан авахад 99,045.2 мянган төгрөгийг зарцуулж, 740,416.8 мянган төгрөгийн харилцахын үлдэгдэлтэй байна.

Үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл 1,734,036.9 мянган төгрөг байгаа нь 740,416.8 мянган төгрөг хэмнэсэнтэй холбоотой байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 153 мэдээллээс хугацаандаа оруулсан 126 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 27 мэдээлэл байгаа нь тус ангийн байрыг тусгаарлаж ашиглах байраар ажиллуулж ажлын байранд орж, гарах хөдөлгөөнийг хорисонтой холбоотой.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрлэлтэд хамрагдсан байна.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 76,178.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9,178.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 67,000.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

#### **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Машин тоног төхөөрөмжийн элэгдлийг 9,178.3 мянган төгрөгөөр дутуу тооцоолсоныг залруулав.

Аудитаар илэрсэн 67,000.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Онцгой нөхцөл байдалтай холбоотойгоор тусгаарлалтын орлого хүлээн авч хүнс хангамжийн зардал их хэмжээгээр нэмэгдэж байгаа нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Дэлхийг хамарсан Ковид-19 цар тахал дотоодод тархсаны улмаас хатуу хөл хорио тогтоосноос шалтгаалан цахимаар аудитыг хийсэн нь үндсэн хөрөнгө, бараа материалын дансны үлдэгдэлд биет тест хэрэгжүүлж тооллого хийх, санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулах боломжгүй байсныг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй.

#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### *Цахим төлбөрийн баримттай холбоотой асуудал*

- 1.1. Илрүүлэлт: Харилцах дансны хуулгыг төлбөрийн цахим системд бүртгэсэн худалдан авалтын баримттай тулгахад 67,000.0 мянган төгрөгийн баримт илгээгдээгүй байна.
- 1.2. Эрсдэл: Цахим системд нэвтэрч байгаатай холбоотойгоор нягтлан бодох бүртгэлд тусгах ажил гүйлгээг цахим баримтаар баталгаажуулахгүй байх нь тухайн зардал бодитоор гараагүй байх.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4-т заасан аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна гэсэн заалтыг дагаж мөрдөх.
- 1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:  
Зөвлөмжийг мөрдөн ажиллана.

##### *Зарцуулалтыг тулган баталгаажуулахтай холбоотой асуудал*

- 2.1. Илрүүлэлт: Тайлант онд ОБЕГ-аас үйл ажиллагааны санхүүжилтанд авсан 550,000.0 мянган төгрөг, тусгай хувцас хэрэглэлд 754,500.0 мянган төгрөгийн зарцуулалтыг дээд шатны төсвийн захирагчаар хянуулаагүй байна.
- 2.2. Эрсдэл: Дээд шатны байгууллагаас олгосон санхүүжилтыг зориулалтын дагуу зарцуулахгүй байх.
- 2.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг дагаж мөрдөх.
- 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:  
Зөвлөмжийг мөрдөн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

|                              |                                                                  |                                                                                                                                               |                       |
|------------------------------|------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|
| Огноо:                       | Аудитын нэр:                                                     | <b>ОБЕГ-ын харьяа Давтан сургалт, сургалт сэргээн заслын төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b> | Аудитын код:          |
| 2021.02.25                   |                                                                  |                                                                                                                                               | САГ-2021./145/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | <b>ОБЕГ-ын харьяа Давтан сургалт, сургалт сэргээн заслын төв</b> |                                                                                                                                               | Мянган төгрөг         |

| №          | Алдаа, зөрчлийн товч утга                                                                                                                                                                           | Мөнгөн дүн      | Аудитын байгуул-лагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны |                      |
|------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------|----------------------------------------|---------------------------------------------------|----------------------|
|            |                                                                                                                                                                                                     |                 | Нэр                                    | Албан тушаал                                      | Овог нэр             |
|            | 1                                                                                                                                                                                                   | 2               | 3                                      | 4                                                 | 5                    |
| 1          | Харилцах дансны хуулгыг төлбөрийн цахим системд бүртгэсэн худалдан авалтын баримттай тулгахад 67,000.0 мянган төгрөгийн баримт илгээгдээгүй байна.                                                  | 67,000.0        | Зөвлөмж                                | Ангийн захирагч Нягтлан бодогч                    | Ц.Уранчимэг Х.Цолмон |
| 2          | Тайлант онд ОБЕГ-аас үйл ажиллагааны санхүүжилтанд авсан 550,000.0 мянган төгрөг, тусгай хувцас хэрэглэлд 754,500.0 мянган төгрөгийн зарцуулалтыг дээд шатны төсвийн захирагчаар хянуулаагүй байна. | 0.0             | Зөвлөмж                                | Ангийн захирагч Нягтлан бодогч                    | Ц.Уранчимэг Х.Цолмон |
| <b>ДҮН</b> |                                                                                                                                                                                                     | <b>67,000.0</b> |                                        |                                                   |                      |

[illegible]